



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 127 дугаар тогтоол, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 1,152,231,941.36 (нэг тэрбум нэг зуун тавин хоёр сая хоёр зуун гучин нэгэн мянга есөн зуун дөчин нэгэн төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 466,971,541.19 (дөрвөн зуун жаран зургаан сая есөн зуун далан нэгэн мянга таван зуун дөчин нэгэн төгрөг арван есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг дотооддоо буюу Шүүхийн Ерөнхий зөвлөлийн харьяа Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Н.Батхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэн бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002797



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн
09 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛӨӨС БАЯНГОЛ, СОНГИНОХАЙРХАН, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГИЙН
ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭН БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал		Ашиглалтад орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
		хэмжих нэгж	биет хэмжээ			(төгрөг)	
1	Албан конторын барилга	м.кв	1512	1980	1,152,231,941.36	466,971,541.19	685,260,400.17
					1,152,231,941.36	466,971,541.19	685,260,400.17
НИЙТ ДҮН							
					(нэг тэрбум нэг зуун тавин хоёр сая хоёр зуун гучин нэгэн мянга есөн зуун дөчин нэгэн төгрөг гучин зургаан мөнгө)	(дөрвөн зуун жаран зургаан сая есөн зуун далан нэгэн мянга таван зуун дөчин нэгэн төгрөг арван есөн мөнгө)	(зургаан зуун наян таван сая хоёр зуун жаран мянга дөрвөн зуун төгрөг арван долоон мөнгө)